



ХАСБАНК

ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар



Агуулга

1. Онцлох үйл явдал	03-05
2. Санхүүгийн үзүүлэлтүүд	06-11
3. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	12-13
4. Компанийн засаглал	14

Онцлох үйл явдал

| 2026 оны I улирал



Банк харилцагчийн сегментээ илүү нарийвчлан, жижиг, дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн цогц үйлчилгээг хүргэх зорилготой Бизнес банкны нэгжийг шинээр бий болголоо. Тус нэгж нь 2026 оны эхний улиралд бизнесийн зээлийн багцыг 12.6%-аар өсгөв.



Эрчим хүчний хуримтлуурын систем, нарны инвертер, цахилгаан автомашины цэнэглэгчийн салбарт тэргүүлэгч SygEnergy компанитай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд бизнес болон өрхийн түвшинд тогтвортой ногоон эрчим хүчний шийдлийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



Засгийн газраас зарласан хүүгийн татаас, хөнгөлөлттэй нөхцөл бүхий тариалан үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих зээл, ноолуур боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих зээл болон аялал жуулчлалыг дэмжих зээлийн зээлийн хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлж байна.

Онцлох үйл явдал

2026 оны I улирал



Ирээдүйн саятан эзэмшигчдийнхээ цаашдын санхүүгийн хэрэгцээнд нийцүүлэн, шатлан өсөх хүүтэй “Ирээдүйн өсөлт залуусын хадгаламж”-ийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ.




Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн нөхцөлийг сайжруулж, зээлийн дээд хэмжээг 1 тэрбум төгрөг болгон 2 дахин нэмлээ.



Нийгмийн хариуцлагын хүрээнд багийн спортыг дэмжин Хасын хүлэгүүд багийг 23 дахь жилдээ тогтвортой дэмжин ажиллаж байна.

Онцлох үйл явдал

2026 оны I улирал



Санхүүгийн үр дүн

2026 оны I улирал

Цэвэр ашиг	ROE	ХАС (Хувьцааны ханш)	EPS	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
₮42.4 тэрбум	19.4%	₮1,075	₮ 161.6	20.1%	34.1%

Ашигт ажиллагаа

- 2026 оны I улиралд ХасБанкны татварын дараах ашиг 42.4 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) 161.6 төгрөгт хүрлээ. Тайлант хугацаанд зээлийн багцын өссөн нь хүүгийн орлого өсөхөд голчлон нөлөөлсөн бол Монголбанктай байгуулсан своп хэлцлийн зардал болон зээлийн чанартай холбоотой нэмэлт сангийн зардал өссөн нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна.
- Өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 19.4 хувьд хүрч өмнөх улирлаас 2.4 суурь нэгжээр буурсан байна.

Баланс

- 2026 оны 3 сарын эцсийн байдлаар нийт хөрөнгө 6,811 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 0.7 хувиар буурсан бол хүүгийн орлого олдог актив 0.5 хувиар өсөж, 5,813 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- Нийт зээлийн багц өмнөх улирлаас 4.6 хувиар өсөж, 4,374 тэрбум төгрөгт хүрэхэд санхүүгийн түрээс, иргэдийн болон бизнесийн банкны зээлийн багцын өсөлт голчлон нөлөөлжээ. 2026 оны I улиралд санхүүгийн түрээсийн багц 9.7 хувиар өсөж, 723 тэрбум төгрөг, иргэдийн зээлийн багц 4.4 хувиар өсөж, 2,595 тэрбум төгрөг, бизнесийн банкны зээлийн багц 12.6 хувиар өсөж, 253 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Харин байгууллагын банкны зээлийн багцын өсөлт саарсан байна.
- Чанаргүй зээлийн харьцаа тогтвортой 2.5 хувь байгаа нь банкны салбартаа тэргүүлэх үзүүлэлт юм.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ өмнөх улирлаас 1.8 хувиар буурч, 3,686 тэрбум төгрөгт хүрсэн байна. Улирлын чанартай харилцах дансны үлдэгдэл 9.8 хувиар буурсан бол Ирээдүйн саятан болон хугацаатай хадгаламжийн хувьд 1.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- 2026 оны I улиралд хуваарийн дагуу гадаад эх үүсвэрийн эргэн төлөлтөөс үүдэн гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 530 сая ам.долларт хүрч буурсан байна. Энэ нь 2025 оны жилийн эцэстэй харьцуулахад 18 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Харьцаа үзүүлэлт


- 2026 оны I улирлын байдлаар Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохих хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 20.1 хувь буюу доод хэмжээг 7.6 нэгж хувиар давуулан биелүүлсэн байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2026 оны 3 сарын 31-ний байдлаар 34.1 хувьтай байгаа нь зохистой харьцааг хангаж байна.

Санхүүгийн үзүүлэлтийн тренд

2026 оны I улирал


Цэвэр ашиг

Тэрбум төгрөг




Нийт актив

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж


Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа




Зээлийн үйл ажиллагаа

2026 оны I улирал

Нийт зээлийн тоо	Онлайн зээлийн тоо	Иргэдийн банк зээлийн тоо	Байгууллагын банк зээлийн тоо	Бизнесийн банк зээлийн тоо	ХасЛизинг с.түрээсийн тоо
216.7 мянга ▲ +0.3% QoQ	143.9 мянга ▼ -0.5% QoQ	210.7 мянга	0.2 мянга	0.4 мянга	5.4 мянга


Зээлийн багц

Тэрбум төгрөг



Зээлийн багц

Тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



Дотоод эх үүсвэр

2026 оны I улирал


Нийт дансны тоо
1.5сая ▲ +1.1% QoQ

Харилцах дансны тоо	Хадгаламжийн дансны тоо
970.7мянга	560.6мянга

Нийт харилцагчдын тоо
1.2сая ▲ 1.2% QoQ

Харилцах, хадгаламж

Тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



- Нийт харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл 3,686 тэрбум төгрөгт хүрэв.
- Улирлын чанартай бизнес идэвхжилтээс үүдэн харилцах дансны үлдэгдэл өмнөх улирлаас 9.8 хувиар буурсан бол Ирээдүйн саятан болон хугацаатай хадгаламж өмнөх улирлаас 1.8 хувиар өссөн байна.
- 3 сард ирээдүйн саятан эзэмшигчдийн санхүүгийн хэрэгцээнд нийцүүлэн, шатлан өсөх хүүтэй “Ирээдүйн өсөлт залуусын хадгаламж”-ийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлээ.


Гадаад эх үүсвэр

2026 оны I улирал

2026 оны I улиралд нийт 5 сая ам.долларын гадаад эх үүсвэрийг WaterEquity хөрөнгө оруулалтын байгууллагаас татан төврүүлсэн бол хуваарийн дагуу нийт 18 сая ам.долларын эх үүсвэрийг эргүүлэн төлсөн байна. Улмаар нийт гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 530 сая ам.долларт хүрлээ. Мөн 2025 оны 12 сард Нидерландын Хөгжлийн Агентлагтай байгуулсан 150 сая ам.долларын синдикат зээлийн эх үүсвэрийг хараахан татан төвлөрүүлээгүй байгаа бөгөөд эх үүсвэрийн хэрэгцээнд үндэслэн татан төвлөрүүлэх төлөвтэй байна.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



Шинээр гадаад эх үүсвэр олгосон байгууллагууд



\$5,000,000

2026 оны 3 сард WaterEquity хөрөнгө оруулалтын байгууллагаас 5 сая ам.долларын санхүүжилт татлаа. Тус эх үүсвэрийг усны хүрэлцээг дэмжих төсөл болон өрх гэрийн усны хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд зориулан зарцуулах болно.

Хувьцааны мэдээлэл

2026 оны I улирал

ХасБанк ХК (ХАС)-ийн хувьцааны үнэ 2026 оны 3 сарын 31-ний өдөр 1,075 төгрөгөөр хаагдсан нь өмнөх оны хаалтын ханшаас 25.9 хувь, IPO хийсэн үнээс 58.8 хувиар өслөө. ХАС-ийн IPO хийснээс хойших нийт өгөөж (хувьцааны үнийн өсөлт болон ногдол ашгийн өгөөжийн нийлбэр) 2026 оны I улирлын байдлаар 73.2% байна.

ХасБанк ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг Монголбанкны холбогдох зөвшөөрлийн дагуу 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд ХасБанк 2026 оны I улиралд 123,105 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авсан ба нийт халаасны хувьцаа 3 сарын 31-ний өдрийн байдлаар 2,853,223 ширхэгт (нийт эргэлтэд гаргасан хувьцааны 0.27%) хүрсэн байна.

2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18 төгрөг буюу нийт 18.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2025 оны 10 сарын 16-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан бол 2025 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 30 төгрөгийн ногдол ашгийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэний дараа 2026 оны 4 сард багтаан тараах төлөвтэй байна.


ХАС хувьцааны ханш, нэгж хувьцаанд ногдох өөрийн хөрөнгө



* - 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгийг жилд хөрвүүлэн тооцов.

Ногдол ашиг хуваарилалт

Тэрбум төгрөг



** - IPO ханш буюу нэгж хувьцааны ханш 677 төгрөгт үндэслэн тооцов.

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


2026 оны I улирал

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

20.1% Байвал зохих доод хэмжээ 12.5%


Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

34.1% Байвал зохих доод хэмжээ 25.0%



Түргэн борлогдох актив

2,009.8 тэрбум төгрөг



Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал	2025 IV улирал	2026 I улирал
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-1.7%	-2.0%	-4.9%	-0.6%	-1.2%	-3.5%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-2.0%	-3.3%	-5.7%	-1.4%	-1.2%	-4.9%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	41.7%	51.7%	46.3%	51.8%	54.8%	53.2%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.2%	1.2%	1.1%	1.1%	1.1%	1.1%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.9%	7.0%	6.8%	6.9%	8.0%	7.6%

	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал	2025 III улирал	2025 IV улирал	2026 I улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	2.2%	1.7%	0.9%	1.0%	2.0%	0.9%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%

Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	2.3%	1.8%	0.9%	1.0%	2.0%	1.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.3%	0.3%	0.4%	0.4%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	0.1%	0.0%	0.1%	0.1%	0.1%	0.0%

Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын хурал

2026 оны I улирал

Төлөөлөн удирдах зөвлөл

3

Хурал

1

Цахим санал
хураалт

21

Тогтоол

2

Сонирхлын
зөрчилтэй
хэлцэл



Засаглал, цалин
урамшууллын
хороо

1 удаагийн хурал



Эрсдэлийн
удирдлагын
хороо

1 удаагийн хурал
3 удаагийн цахим
санал хураалт



Нэр дэвшүүлэх
хороо

2 удаагийн хурал
1 удаагийн цахим
санал хураалт



Аудитын
хороо

2 удаагийн
хурал

Нэмэлт, өөрчлөлт оруулсан:



- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дүрэм
- Ажилтны зээлийн ерөнхий журам



 (976)-75771888-(888)

 investor-relations@xacbank.mn

 <https://www.xacbank.mn>